

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,  
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/263 А/106.321

Улаанбаатар хот

Захиргааны хэлтэст  
актын үлсэл нэгдсэн санд  
2017 оны 11 сарын 01-ны  
тухай хүт

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2, 39.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан "Журам батлах тухай" 2017 оны А/155, А/176,142 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журам"-ын гуравдугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.5, 3.6 дахь заалт нэмсүгэй.

3.5.Насанд хүрээгүй иргэнийг үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулна.

3.6.Яаралтай үзлэг, шинжилгээ хийх шаардлагатай тохиолдолд энэ журмын 3.4-д заасан баримтыг шаардахгүй.

2.Дээрхи тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Шүүх эмнэлгийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ"-ний Цогцост хийх шинжилгээний хэсгийн 5-д заасан "Цогцост хийх шинжилгээ /0-18 насны/- 30000" гэснийг хүчингүй болгосугай.

